

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН КОМПАНИЙН ТУХАЙ (1999) ХУУЛИЙН 42, 43 ДУГААР ЗҮЙЛ,
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ (2002) ХУУЛИЙН 4, 5 ДУГААР ЗҮЙЛИЙГ
ҮНДЭСЛЭН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БОНД ГАРГАЖ БАЙНА.



Бондын хугацаа:	12 сар
Хүүгийн хэмжээ /жилийн/:	16.2%
/сарын/:	1.35%
Хүү төлөх хугацаа:	Улирал тутам
Эргүүлэн авах нөхцөл:	Хугацаа бүрийн эцэст нэрлэсэн үнээр
Бонд гаргах зорилго:	Мал бэлтгэлийн ажлыг санхүүжүүлэх
Бондын баталгаа:	Үл хөдлөх хөрөнгөөр баталгаажна
Нийт үнийн дүн:	30,000,000,000 төгрөг

Бонд эзэмшигчдийн бүртгэл,
төлбөр тооцоо, хадгаламж: “Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн
Төв” ТӨХХК

Бонд арилжаалагдах зах зээл: Монголын Хөрөнгийн Биржийн арилжаагаар дамжуулан
олон нийтэд нээлттэй арилжаална.

Бондын үндсэн болон хүүгийн
төлбөрийн хугацаа хэтрэлт: Хүү төлөх өдрөөс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүүгийн
төлбөрөөс 0.02%-иар алданги нэмж тооцон хүүг
алдангийн хамт Үнэт цаас эзэмшигчид төлнө.

АНДЕРРАЙТЕР



Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
“БиДиСЕК” Хувьцаат Компани
Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
Хаяг: УБ, СБД 8 хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 байр
Утас: 976-11-323411, 11-313108
Факс: 976-11- 321763, 11-323411
И-мэйл: info@bdsec.mn, www.bdsec.mn



“ЖАСТ АГРО” ХХК

“Жаст групп” ХХК нь өөрийн хөрөнгө оруулалтаар сүүлийн 10 гаруй жилд хөдөө орон нутагт байрлах мах боловсруулах үйлдвэрүүдийг худалдан авч, нэмэлт хөрөнгө оруулалт хийснээр бүх үйлдвэрүүд нь стандартын шаардлага хангасан, бүрэн ажиллагаатай бизнесийн нэг нэгдэл болж чадсан. Энэхүү нэгдлийг 2007 онд “Жаст групп” ХХК-ийн 100 хувийн охин компани болох “Жаст агро” ХХК болгон зохион байгуулсан.

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хүрээнд техник, технологийн шинэчлэлтийг ээлж дараатай хийснээр “Жаст агро” ХХК нь Монгол Улсын хэмжээний бэлдсэн мал бэлтгэлийн 32.3 хувь (41,634 толгой мал бэлтгэсэн), үйлдвэрийн аргаар мал төхөөрөх хүчин чадлын 26 хувь (нэг ээлжинд бод-1810, бог-8900 толгой), мах махан бүтээгдэхүүн хадгалах хүчин чадлын 30 (19,200 тн), махны экспортын 22.8 (2010 оны байдлаар 4518.9 тн-ыг экспортлосон) хувийг дангаараа хангах болсон. Мөн үйлдвэрийн аргаар бэлтгэж буй нийт махны 40 орчим хувийг үйлдвэрлэн, улсын нөөцийн махны 1/3-ийг дангаар хангаж байна.

Малыг алс холоос, дундын зуучлагчаар дамжуулдаг байсан мал бэлтгэлийн өртөг өндөртэй аргыг 2006 оноос халж, бүсчлэн мал бэлтгэх шинэ аргыг нэвтрүүлсэн. Энэ нь малыг хамгийн алсдаа 50-200 км-т тууварлан үйлдвэрт нийлүүлэх боломжтойгоор 11 аймаг, орон нутгийг хамарсан томоохон сүлжээ үйлдвэрүүдийг бий болгоод байна. Тус том систем нь зах зээлд хямд үнэтэй, үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжийг бүрдүүлж чадсан.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2006 оноос үйлдвэрүүдэд нэмэлт хөрөнгө оруулалт хийж сэргээн засварлалт хийснээр урьд нь ашиглаж байсан фероны хөргөлтийг 2010 онд бүрэн зогсоож, хөргөлтийн системийг бүрэн шинэчилсэн. Мөн 2010 оноос УБ мах маркетаас эхлэн “Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах / Hazard analysis and Critical Control Point/ системийг нэвтрүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдийн сургалтанд хөрөнгө оруулалтыг хийж эхлээд байна.

Үзүүлэлт (сая.төг)	2006	2007	2008	2009	2010	Нийт
Үйлдвэр	89.8	1,940.0	1,264.9	6,659.9	285.2	10,239.9
Үйлдвэрийг шинэчлэн засварлах	109.4	195.8	703.7	96.9	520.4	1,626.2
Үйлдвэрийн өргөтгөл	48.8	189.0	485.5	19.9	-	743.2
Тоног төхөөрөмж худалдан авалт, угсралт	36.8	418.9	524.0	1,138.4	2,105.7	4,223.8
Үндсэн хөрөнгө худалдан авалт	-	474.3	160.3	12.0	4.1	650.7
Төв үйлдвэр	-	6,786.1	3,554.3	-	-	10,340.3
Зам, байгууламж	2.6	-	-	71.0	340.1	413.7
Нийт дүн	287.4	10,004.2	6,692.7	7,998.1	3,255.5	28,237.8

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулалтыг шат дараатай хийснээр дараах давуу талуудыг бий болгоод байна.

- Эрсдлийг тараан байршуулах боломжтой 11 үйлдвэр бүхий бизнесийн сүлжээг бий болгосон,
- Малыг 50-200 километрийн зайд тууварлах болсноор нэг малын махны гарцыг нэмэгдүүлж, улмаар мал бэлтгэлийн үнийн 50-200 төгрөг хүртэлх өсөлтийг даах боломжийг бүрдүүлсэн,
- HACCP /Hazard analysis and Critical Control Point/ системийг бий болгож байна,
- Сэлэнгэ, Багануур, Дорнод, Улаанбаатар зэрэг салбар үйлдвэрүүд нь төмөр замд холбогдсоноор тээвэрлэлтийг түргэн шуурхай болгосон,
- Хүнсний аюулгүй байдлын олон улсын стандарт ISO22000 болон МУ-н үндэсний стандартыг үйлдвэртээ нэвтрүүлэн ажиллаж байна,
- Төв үйлдвэр нь гуравдагч оронд экспортлох эрх бүхий AAA, бүх салбар үйлдвэрүүд нь хөрш оронд экспортлох AA итгэмжлэлтэй,





МЕНЕЖМЕНТ

Үнэт цаас гаргагчийн 100 хувийн хувьцааг эзэмшигч толгой компани нь Монгол Улсын хуулийн этгээд болох “Жаст групп” ХХК болно.

“Жаст групп” ХХК нь 1999 онд газрын тосны бүтээгдэхүүний худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 2000 оноос хөдөө аж ахуйн салбарт, 2006 оноос барилга болон олон улсын худалдааны салбаруудад ажиллаж байна. 2009 онд уул уурхай болон банк, санхүүгийн салбарт томоохон хөрөнгө оруулалтыг хийснээр эдгээр салбарт идэвхитэй үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. 2010 онд ОХУ-ын Москва хот, БНХАУ-ын Бээжин хотноо өөрийн төлөөлөгчийн газрыг нээсэн байна.


Охин компаниуд:

- “Жаст Ойл” ХХК
- “Хадгаламж банк”
- “Жаст Агро” ХХК
- “Маркентайл Хаус” ХХК
- “Олон Овоот Гоулд” ХХК,
- “Эрд Тана” ХХК

“Жаст групп” ХХК нь МҮХАҮТ-аас жил бүр шалгаруулдаг TOP-100 аж ахуй нэгжүүдийн эхний 10-т тогтмол шалгардаг Монгол Улсын томоохон компани юм.

САЛБАР ҮЙЛДВЭРҮҮД

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрүүд нь нэг ээлжинд 10 мянга гаруй толгой мал бэлтгэн төхөөрч, 19.2 мянган тонн мах хадгалах хүчин чадал бүхий аммиакан хөргөлтийн системтэй.



Үйлдвэрийн үйл ажиллагаа нь мал бэлтгэл, боловсруулалт, тээвэрлэлт, борлуулалт гэсэн үндсэн хэсгүүдээс бүрддэг ба эдгээрийг дараах системээр гүйцэтгэж байна.

Мал бэлтгэл: Малыг дундын зуучлагчгүйгээр шууд үйлдвэр дээрээ, амьдын жингээр тооцон худалдан авч, Хадгаламж банкны 400 гаруй салбар, тооцооны төвтэй хамтран мал бэлтгэлийг гүйцэтгэсэн.

Боловсруулалт: НАССР стандартын дагуу мах бэлтгэлийг явуулдаг, төв үйлдвэрт нь ААА зэрэглэлийн, компанийн бүх салбарууд нь АА зэрэглэлийн итгэмжлэлтэй.

Тээвэрлэлт: Орон нутгийн үйлдвэрээс 20 тонны багтаамжтай хөргүүртэй 3 машин, 20 тонны багтаамжтай задгай 2 машинаар, экспортын тээвэрлэлтийг төмөр замаар хийдэг ба Сэлэнгэ, Багануур, Улаанбаатар хотын үйлдвэрүүд нь төмөр замын оролтоор Транс – Монголын төмөр замд холбогдсон.

Борлуулалт: Сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг гадаад зах зээлд нийлүүлэх бодлого баримтлаж, энэ чиглэлийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ажиллаж байна.





Үйлдвэрүүдийн хүчин чадал

	Үйлдвэрийн нэр	Хоногт нядлах хүчин чадал (тоо, толгой)		Хөргөлтийн хүчин чадал (тн)	Гүн хөлдөөлтийн хүчин чадал (хоног/тн)
		Бод	Бог		
1	Улаанбаатар Мах маркет	-	1,000	7,000	20
2	Баян-Өлгий Мах маркет	120	800	1,000	20
3	Булган Мах маркет	120	700	500	20
4	Завхан Мах маркет	120	-	500	15
5	Сүхбаатар Мах маркет	120	800	750	20
6	Увс Мах маркет	80	400	250	15
7	Дорнод Мах маркет	200	1,600	3,000	60
8	Хөвсгөл Мах маркет	200	500	1,000	40
9	Багануур Мах маркет	300	1,000	1,200	40
10	Сэлэнгэ Мах маркет	350	1,600	3,000	40
11	Өвөрхангай Мах маркет	200	500	1,000	/дуусаагүй/
	Нийт	1,810	8,900	19,200	290

Үнэт цаас гаргагч нь малыг шууд үйлдвэр дээрээ худалдан авч технологийн дагуу боловсруулж байгаа нь бэлтгэсэн махны чанарыг сайжруулж, өртгийг хямдруулаад зогсохгүй малчин өрхийн амьжиргааг тэтгэх, малын хулгайтай тэмцэх зэрэг нийгмийн чухал ач холбогдолтой ажил болж байна.

Мах бэлтгэлийн тоо, махны гарц

Нэр төрөл	2007 он		2008 он		2009 он		2010 он	
	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц/%	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц/%	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц/%	Бэлтгэсэн малын тоо	Нэг малын махны гарц/%
Үхэр	16,703	42.3	19,765	45.2	25,468	46.3	6,238	47.7
Адуу	3,335	44.5	4,615	47.4	9,521	49.9	4,152	51.5
Хонь	33,902	40.1	55,911	42.1	860	41.9	23,374	42.3
Ямаа	4,235	39.1	8,273	36.5	1,116	-	7,870	41.9
Бүгд дүн	58,175	-	88,564	-	36,965	-	41,634	-





БОРЛУУЛАЛТ


Компани нь бод, богийн тураг мах, ангилсан мах, дайвар бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн доорхи чиглэлээр борлуулалтыг хийж байна.



Сүүлийн жилүүдэд экспортын чиглэлд түлхүү анхаарснаар борлуулалтанд экспортын эзлэх хэмжээ өссөн.



Сүүлийн жилийн нийт борлуулалтын бүтцийг үзвэл дараах байдалтай байна.



Худалдааны гэрээ: Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр бэлдсэн бүтээгдэхүүнийг борлуулах баталгаа болгон нийт 55,6 тэрбум төгрөгийн (тодорхойлолт гаргах өдрийн байдлаар) борлуулалтын гэрээ байгуулсан.

- “Бурятмяспром” компанитай 30 720 000 /гучин сая долоон зуун хорин мянга/-н ам.долларын үнийн дүн бүхий 12,000 тн адуу, үхрийн мах нийлүүлэх гэрээ,
- Лалын Бүгд Найрамдах Иран Улс руу 4600 /дөрвөн мянга зургаан зуу/-н тонн хонины мах экспортлох гэрээ хийгдсэн.

Үнэт цаас гаргагч нь Бүгд Найрамдах Буриад Улсын “Бурятмяспром” ХХК-тай олон жилийн тогтвортой харилцаатай үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Тус компанид нийлүүлсэн бүтээгдэхүүний орлого нь “Жаст Агро” ХХК-ийн сүүлийн 4 жилийн экспортын борлуулалтын 86.4 хувийг эзэлж байна.

“Бурятмяспром” ХХК нь 1937 онд байгуулагдсан бөгөөд махны импортоороо дэлхийд тэргүүлэгч ОХУ-ын хамгийн том 10 мах үйлдвэрлэгч компанийн нэг юм. Тэр дундаа Сибирь, алс дорнодын бүсийн хамгийн том махны үйлдвэр бөгөөд өдөртөө 130 мянган ширхэг лаазалсан бүтээгдэхүүн, 20 тонн хиам, 10 тонн дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт (мян.төг)

Үзүүлэлт	2009	2010	2011.Q2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	18 060,9	16 940,5	52 106,3
Дансны авлага	2 098 278,2	345 816,6	184 638,9
Холбоотой талуудын тооцоо		1 900 000,0	1 066 884,0
Бараа материал	8 196 365,9	3 312 597,1	2 876 561,5
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо			96 490,3
Эргэлтийн хөрөнгийн дүн	10 312 705,0	5 576 354,3	4 276 681,0
Үндсэн хөрөнгө (цэвэр) ДҮ	29 302 310,2	32 591 047,3	47 368 412,3
Биет бус хөрөнгө	3 558,4	3 163,0	2 965,4
Хөрөнгө оруулалт ба бусад			2 000,0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29 302 310,2	32 591 047,2	47 373 377,7
Нийт хөрөнгө	39 615 015,2	38 167 401,5	51 650 058,6
Дансны өглөг	2 819 494,9	1 025 513,1	420 467,0
Бусад өглөг	6 342,8	21 492,0	8 861,0
Холбоотой талд өгөх өглөг	7 109 912,7	2 469 871,8	
Банкны зээл		1 900 000,0	2 815 000,0
Урьдчилж орсон орлого		116 170,1	127 830,0
Богино хугацаат өрийн дүн	9 935 750,5	5 533 047,1	3 372 158,0
Урт хугацаат өр төлбөр	24 982 391,0	28 237 845,2	468 187,2
Өр төлбөрийн нийт дүн	34 918 141,6	33 770 892,3	3 840 345,3
Эзэмшигчдийн өмчийн дүн	4 696 873,5	4 396 509,1	47 809 713,4
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	39 615 015,2	38 167 401,5	51 650 058,6
ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Борлуулалтын орлого	10 309 506,1	17 799 654,3	3 675 716,4
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6 000 055,3	8 874 999,7	1 712 994,7
Нийт ашиг	4 307 371,7	8 922 783,1	1 962 721,7
Үйл ажиллагааны зардал	7 156 014,1	9 154 150,9	1 874 915,5
Үйл ажиллагааны ашиг	(2 848 642.4)	(231 367.7)	87 806,2
Татварын өмнөх ашиг	(2 081 963.3)	143 850.5	73 953,2
Татварын дараах цэвэр ашиг	(2 081 963.3)	123 340.9	64 042,8



БОНД ГАРГАХ ШИЙДВЭР

- Үйлдвэр нь суурилагдсан хүчин чадлаараа жилд 375 мянган толгой мал боловсруулах хүчин чадалтай хэдий ч эргэлтийн хөрөнгийн дутагдлаас сүүлийн 4 жилд нийт хүчин чадлын 30 хүрэхгүй хувийг ашигласан. Иймд Үнэт цаас гаргагч нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээр хүчин чадал ашиглалтын түвшинг 80 хувьд хүргэхээр төлөвлөж байна.


- Эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг арилжааны банкнаас зээл авч санхүүжүүлэхэд тухайн зээл олгох банкнаас шалтгаалан өөрийн хөрөнгийн 20-30 хувь хүртэлх хэмжээгээр зээлийн хязгаар тогтоосон байдаг нь хангалттай хэмжээний санхүүжилт татахад бэрхшээл учруулж байгаа.

- “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирлын тушаалаар эргэлтийн хөрөнгийг олон нийтэд бонд гарган татан төвлөрүүлэхээр 2011 оны 1 сард шийдвэрлэсэн.

Бондын нөхцөл

Нэрлэсэн үнэ:	10,000 төгрөг
Нийт ширхэг:	3,000,000 ширхэг
Нийт үнийн дүн:	30,000,000,000 төгрөг
Бондын хугацаа:	12 сар
Хүүгийн хэмжээ жилийн, /сарын/:	16.2% , /1.35%/
Хүү төлөх хугацаа:	Улиралд нэг удаа
Анхдагч зах зээлд байршуулах:	10 тэрбумаар хэсэгчлэн 3 хуваан анхдагч зах зээлд байршуулна
Эргүүлэн авах нөхцөл:	Хугацаа бүрийн эцэст нэрлэсэн үнээр
Бонд гаргах зорилго:	Мал бэлтгэлийн ажлыг санхүүжүүлэх
Бондын баталгаа:	Үл хөдлөх хөрөнгөөр баталгаажна
Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлт:	Хүү төлөх өдрөөс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүүгийн төлбөрөөс 0.02%-иар алданги нэмж тооцон хүүг алдангийн хамт Үнэт цаас эзэмшигчид шилжүүлнэ.
Бонд эзэмшигчдийн бүртгэл, төлбөр тооцоо, хадгаламж:	“Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК
Бонд арилжаалагдах зах зээл:	Монголын Хөрөнгийн Биржийн арилжаагаар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаална.

Компанийн бондын болон арилжааны банкны хүүгийн түвшин /10 жилээр/



БОНДЫН БАТАЛГАА

Үл хөдлөх хөрөнгө: Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн 31,62 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий мах бэлтгэх, боловсруулах 8 үйлдвэрээр бондын эргэн төлөлтийн баталгаа гаргаж байгаа.

Бүтээгдэхүүн: Компани нь нийт татан төвлөрүүлэх 30 тэрбум төгрөгөөр 2011 оны мал бэлтгэлээр 310,500 малын махыг боловсруулж, 12,224 тонн тураг мах үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа. Мах нь бондын баталгаа болж чадахуйц, хөрвөх чадвар өндөр бүтээгдэхүүн юм.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг зөвхөн мал бэлтгэлийн үйл ажиллагаанд зарцуулна.

Мал	2011		2012	
	Малын тоо	Бэлтгэх тураг махны хэмжээ (тонн)	Малын тоо	Бэлтгэх тураг махны хэмжээ (тонн)
Үхэр	40,000	5,076.0	44,500	5,647.1
Адуу	20,000	2,800.0	24,000	3,360.0
Хонь	230,000	4,025.0	240,000	4,200.0
Ямаа	20,000	320.0	20,000	320.0
Нийт	310,500	12,224	328,500	13,527
Мал бэлтгэх нийт өртөг	28,295,000,000		32,393,800,000	



ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Орлого (сая.төг)	2011-2012 он	2012-2013 он
Экспорт	29,387.50	32,825.00
Дотоодын борлуулалт	6,702.60	7,521.40
Бусад орлого	4,143.30	4,460.00

Экспортын борлуулалтыг урьдчилан хийгдсэн гэрээний дундаж үнэ (3395 ₮), дотоодын борлуулалт нь өнгөрсөн жилийн жижиглэнгийн борлуулалтын дундаж үнэ (2900₮)-ээр тооцож төлөвлөгөө хийгдсэн.

Ашгийн төлөвлөгөө: (сая.төг)	2011-2012	2012-2013
Борлуулалтын орлого	40,233.40	44,806.50
Нөөцийн махны урамшуулал	1,200.00	1,200.00
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	30,327.50	34,290.20
Нийт ашиг	11,105.90	11,716.30
Удирдлага, маркетингийн зардал	1,987.80	1,977.60
Элэгдлийн зардал	1,754.30	2,279.70
Санхүүжилтийн зардал	4,787.00	842
Үйл ажиллагааны ашиг	2,576.60	7,020.50
Үйл ажиллагааны бус орлого, зардал	403.6	403.6
Татварын зардал	298.1	702
Цэвэр ашиг	2,682.10	6,318.50

Ашгийн таамаглалыг хийхдээ санхүүгийн жилийг мах үйлдвэрлэлийн нэг удаагийн мөчлөгийн үргэлжлэх хугацаагаар 2011/7/01-наас дараа оны 6 сарын 30-ны өдөр хүртэл гэж тооцоолсон.

МОНГОЛ МАХ БОНД (ММБ)

Хөрөнгө оруулагчдын хүртэх ашиг:

- Өндөр хүү 16,2%, арилжааны банкуудын хадгаламжийн хүүтэй харьцуулахад даруй 51,4%, МУ-н Засгийн газрын 1 жилийн хугацаатай бондын хүүтэй харьцуулахад 2 дахин өндөр, улирлаар бондын хүүгээ авах боломжтой,
- Хоёрдогч зах зээл дээр арилжаалах боломжтой,
- Хувь хүний хүүгийн орлогоос олох ашгийг 2013 он хүртэл ОАТ-аас чөлөөлсөн,
- Төгрөгийн ханш чангарах төлөвтэй байгаа,

Найдвартай байдал:

- Олон жил мал бэлтгэлийн үйл ажиллагаа явуулсан туршлагатай, зах зээлд байр сууриа олсон компанид хөрөнгө оруулалт хийх,
- ММБ нь "Жаст Агро" ХХК-ын үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан,
- Монгол Улсын 11 аймагт салбар үйлдвэрүүдтэй бөгөөд малчдад хамгийн ойрхон,
- Экспортын гэрээнүүд хийгдсэн,


ММБонд олон нийтэд санал болгож буйтай холбогдуулан худалдан авалт хийхээр сонирхож буй хөрөнгө оруулагчид

- Монгол Улсын арилжааны томоохон банк болох Голомт банк нийт гаргаж буй бондын 1/3-тэй тэнцэх үнийн дүнд бонд худалдан авах урьдчилсан санамж байгуулсан,
- Андеррайтер "БиДиСЕК" ХК нь бондоос худалдан авалт хийх гэрээ хэлцэл хийсэн,

МАХНЫ ЗАХ ЗЭЭЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ДАХЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭМЖЛЭГ

Манай улсын эдийн засгийн 30 орчим хувийг ХАА салбарын үйлдвэрлэл эзэлж, инфляцийн өөрчлөлтийн 90 орчим хувийг мах махан бүтээгдэхүүний барааны бүлэг эзлэж байгаа нь тус салбар нь эдийн засагт өндөр ач холбогдолтойг илэрхийлнэ. 2010 оны үзүүлэлтээр Монгол Улс нэг хүнд ногдох махны хэрэглээгээрээ дэлхийд 10-рт бичигдэж, нэг хүн жилд 108,8 кг мах хэрэглэж байгаа нь дэлхийн дундажтай харьцуулахад 2,7 дахин их байна.

Махны дундаж үнэ



Манай улс 2010 оны жилийн эцсээр 32,8 сая толгой мал тоолуулсан. Улсын хэмжээнд жилд дунджаар нийт малын 13-15 хувь буюу 8 сая орчим толгой мал (хонин толгойд шилжүүлснээр) хүнсэнд хэрэглэж, 230 орчим тонн мах дотоодын хэрэглээнд ашигладаг ба сүүлийн 10 жилд махны үнэ дунджаар 4,5 дахин өссөн байна.

Махны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Засгийн газраас доорх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

- Манай улс 2006 оноос эхлэн махны хангамж үнийг тогтворжуулах зорилгоор хот, суурин газрын хүн амын хавар, зуны хэрэгцээнд зориулж мах нөөцлөх арга хэмжээг авч, нөөцийн мах бэлдсэн компаниудыг урамшуулж ирсэн ба Үнэт цаас гаргагч нь жил бүр нөөцийн мах бэлтгэлийн 30 орчим хувийг бэлдэн оролцож байна.
- Төр засгаас мах бэлтгэл, боловсруулах үйлдвэрүүдийг хууль эрх зүйн орчноор дэмжих зорилгоор тодорхой алхмуудыг хийж байна. Үүнд: Хүн амын хүнсний хангамжинд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс НӨАТ-аас чөлөөлсөн.



Монголын Хөрөнгийн биржийн гишүүн
БиДиСЕК ХК
Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх



АНДЕРРАЙТЕРЫН КОМПАНИ

“БиДиСЕК” ХК нь 1995 онд байгуулагдаж, хөрөнгийн зах зээл дээр 16 жил амжилттай ажиллаж буй андеррайтер, брокер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үндэсний ууган компани юм. Компани нь 2006 оны 6-р сард зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалж хөрөнгийн зах зээл дээрээс 1 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн. Мөн 2008 онд нэмэлт хувьцаа гарган хөрөнгийн зах зээлээс 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлэх замаар үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж байна.

Бид 2005 оны 6-р сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолоор андеррайтерын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан тэргүүлэгч андеррайтерын компани юм. Монголын Хөрөнгийн зах зээл дээр 2005-2011 оны 8 сар хүртэл нийт 16 компани үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн бол “БиДиСЕК” ХК нь 11 компанийн андеррайтераар ажилласан.

Мөн 2004, 2005 онд “Пума групп”-ийн Пума бонд, 2005 онд “Монинжбар” ХК-ийн “Бүтээн байгуулалт бонд”, 2007 онд “Нийслэл өргөө” ХК-ийн “Нийслэл өргөө бонд”-ын ерөнхий зуучлан борлуулагч, 2004 онд “М-Си-Эс электроникс” ХХК-ийн “М-Си-Эс электроникс бонд”-ыг зуучлан хамтран ажилласан туршлагатай.



БОНДЫН МЭДЭЭЛЛИЙГ:

Б.Лхамдолгор

Ахлах мэргэжилтэн
Утас: 976-99010589
lhamdolgor@bdsec.mn

Б.Ганболд

Мэргэжилтэн
Утас: 976-99012845
ganbold@bdsec.mn

БОНД ХУДАЛДАН АВАХ:

Ш.Шинэбаяр

Харилцагчийн албаны менежер
Утас: 976-99010211
shinee@bdsec.mn

О.Уранбайгаль

Ахлах брокер
Утас: 976-99010288
baigal@bdsec.mn

Үнэт цаасны танилцуулга татаж авах холбоос: www.bdsec.mn, www.justgroup.mn, www.mse.mn, www.frc.mn